



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 232

Улаанбаатар хот

“Соёмбо даатгал” ХХК-ийн
ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрлийг сэргээх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.4, Даатгалын тухай хуулийн 13.1.2, 13.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хууль тогтоомжид заагдсан төлбөрийн чадварын шаардлагын шалгуур үзүүлэлтүүдийг хангаж, Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэн, гаргасан зөрчлөө арилгасан тул “Соёмбо даатгал” ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээсүгэй.

2. Дахин зөрчил дутагдал гаргахгүй, холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж, даатгуулагчдын хууль ёсны эрх ашгийг дээдлэн ажиллахыг “Соёмбо даатгал” ХХК /Б.Мөнхтуяа/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

001650